



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Худалдан авах ажиллагаа

Худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг батлуулан 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга, хэмжээний худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж Худалдан авах ажиллагааны 2017 оны тайлан 2018 оны хагас жилийн тайланг нэгтгэн Сангийн сайдын 363 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хагас жилээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан 31 ажлаас 30 ажлын худалдан авалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас эрх шилжиж ирсэн нийт 14 тендерийг зохион байгуулан 11 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 3 ажлыг тендерийг зарласан тендер хүлээн авах шатандаа байна. Бусад байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 8 ажлын худалдан авалтыг зохион байгуулж нийт 52 ажлын худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

2018 онд нийт **12.732.700.000** төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж **130.300.000** төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажилласан байна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Завхан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд тусгагдсан /Төлөвлөгдсөн ажлын 50-аас доошгүй хувийг цахимаар хийсэн байна/ заалтыг хэрэгжүүлэн 2018 онд зохион байгуулсан **52** ажлаас **46** ажлын **/88.46%-ийг/** худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд /tender.gov.mn, zavkhan.gov.mn сайтуудад/ оруулан нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс Орон нутгийн төсвийн удирдлагыг сайжруулах сэдвээр худалдан авах ажиллагааны бодлого, анхаарах асуудал, хэрэгжилтийн талаар мэргэшүүлэх сургалтад Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд, сумдын санхүүгийн албаны дарга нар, сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд, тогтвортой амьжиргаа төслийн багийнхан зэрэг нийт 60 албан хаагч хамрагдсан.

Төрийн албан хаагчдын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөнд Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нар болон аймгийн хэмжээн дахь Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн захирал, эрхлэгч нарт Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын талаар болон худалдан авах ажиллагааны журам, хуулийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудад цахим худалдан ажиллагааны талаар заавар зөвлөгөө өгч цахим худалдан авах ажиллагааны системд сумдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг оруулан, цахим хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Өмч хөрөнгийн хүрээнд

Орон нутгийн өмчит 220 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хөрөнгийн мэдээллийг нь холбогдох маягтуудын дагуу шалган авч нэгтгэсэн. Ахлах мэргэжилтэн Б.Бат-Амгалан 3 сарын 12-20-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн системийн бүрдэл дүүргэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар тулган баталгаажуулсан.

Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн харилцааны асуудал хэлэлцсэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 3 удаагийн хурлаар 8 тогтоол гарснаас Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх-3 тогтоол /4 байгууллагын 97.8 сая төгрөгийн хөрөнгө/, Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох-2 тогтоол Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох-1 тогтоол /3 байгууллагын 19.4 сая төгрөгийн хөрөнгө/ Хөрөнгө актлах-2 тогтоол /9 байгууллагын 167.0 сая төгрөгийн хөрөнгө/ тус тус гарсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан Хөрөнгийн дахин үнэлгээ, Нийслэлийн өмчийн газраас туршлага судлах төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, анхаарах асуудал зэрэг сургалтад Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд, ахлах мэргэжилтэн Б.Бат-Амгалан нар хамрагдсан.

Орон нутгийн өмч эзэмшүүлэх 2018 оны гэрээг сумд, байгууллагуудын нягтлан бодогч нартай байгуулан, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Отгонтэнгэрийн рашаан сувиллын менежментийн гэрээг цуцлах шийдвэрийн дагуу хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх

ажлын төлөвлөгөөг батлуулж ажлын хэсэг холбогдох хууль тогтоомжийн дагуу ажлаа зохион байгуулж ажиллаж байна.

2018 оны 05 сарын 09-ны өдрөөс 05 сарын 12-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишигээр ахлуулсан ажлын хэсэг Орон нутгийн өмчийн газар, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК, “Амь Ус” ОНӨҮГ, “Богдын голын усан цахилгаан станц” ХХК-уудад ажилласан. Ажлын хэсэг Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлах, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай танилцах, мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн болон орон нутгийн өмчийн үнэлгээ, дахин үнэлгээний бэлтгэл хангах, сургалт зохион байгуулж ажилласан.

Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварлах ажлын хүрээнд байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, санхүүжилт, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь, эрх бүхий байгууллагаас батлагдсан орон нутгийн өмчийн харилцааны талаар мөрдөгдөж буй журам, заавар, дүрэм, аргачлал, бусад баримт бичиг, ажлын тайлан, “төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн бүрдэл, дүүргэлт, худалдан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал зэргийг шалгаж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК, “Амь Ус” ОНӨҮГ, “Богдын голын усан цахилгаан станц” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон шийдвэр, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэр, хурлын тэмдэглэл, тэдгээрийн хууль, эрх зүйн үндэслэл, хэрэгжилтийн байдал, цалин хөлс, зардал, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтныг томилсон шийдвэр, байгуулсан гэрээ, түүнийг дүгнэсэн байдал, компанийн 2016, 2017 оны жилийн бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан шийдвэр, түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдлыг шалгаж, компанид тулгамдаж буй асуудал болон санал хүсэлтийг нь хүлээн авч, зөвлөгөө өгсөн.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хяналт, зохицуулалт, үнэлгээ, програм хангамжийн дүүргэлтэд анхаарах асуудал” сэдвээр 120 албан хаагчдад сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Байгууллагын дотоод ажил

Аймгийн Засаг даргын захирамжаар “ТӨРИЙН АЖЛЫГ АРД ИРГЭДЭЭРЭЭ ҮНЭЛҮҮЛЭХ” аяны хүрээнд байгууллагын 5-н албан хаагч аймгийн 23 сумдын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.

Байгууллагын 11 ажилтан бүр 1 талдаа төрийн албан хаагчдын баримтлах 9 зарчим, нөгөө талдаа тухайн ажилтны зураг, овог нэр, албан тушаал бүхий 8.5x5.4 хэмжээтэй энгэрийн тэмдэгтэй болон, ажилтан бүр зүүж хэвшсэн.

Аз жаргалтай гэр бүл төслийг хэрэгжүүлж, байгууллагын 3 ажилтнууд болон тэдний гэр бүлийг албан ёсны сургалтад хамруулсан.

Байгууллагын нягтлан бодогч “Шилэн данс”-ны мэдээллийг хариуцан цахим хуудсанд шаардлагатай мэдээллүүдийг Засгийн газрын шилэн дансны нэгдсэн систем <http://shilendans.gov.mn>-д хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна.

Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулж, байгууллагын хариуцсан ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, мод тарих үндэсний өдрөөр 20 ширхэг мод тарьж хариуцсан талбайн зүлэгжүүлэлтийг хийж албан хаагч бүр мод зүлгээ услах хуваарийн дагуу мод зүлгээ усалж, албан өрөөндөө ажилтан бүр цэцэг тарьж ургуулсан.

Албан хаагчдын 2018 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нягтлан бодогч Г.Дашбалжир Төрийн албан хаагчийн шинэчилсэн найруулгын тухай хуулиар сургалт зохион байгуулсан.

ХЯНАСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

Д.БАТМЭНД

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГИЙН ДАРГА

Н.ЖИГЖИДДОРЖ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЦОГТСАЙХАН